

1-р хичээл: Хуралд бэлтгэх, хөтлөн явуулах

Та энэхүү хичээлийг бүхэлд нь эсвэл богино хэсэгт хуваан зааж болно. Хичээлийг заахдаа тухайн орон нутгийнхаа нөхцөл байдалд болон чуулгынхаа эсвэл ангийн ерөнхийлөгчийн зөвлөлийнхөө хэрэгцээ, нас, ойлголтод тулгуурлаарай.

ИХ ЭЗЭН БИДНИЙГ ӨӨРСДИЙГӨӨ ЗОХИОН БАЙГУУЛАХАД УРЬДАГ

[Сургаал ба Гэрээ 88:119](#)-ийг унш. Их Эзэний “Өөрсдийгөө зохион байгуул” гэсэн зааварчилгаа хэрхэн чуулга, ангийн ерөнхийлөгчийн зөвлөлийн хуралд хамааралтай болохыг хэлэлц. Хурлыг зохион байгуулахын тулд бид юу юу хийж чадах вэ?

ХУРЛЫГ ТӨЛӨВЛӨХ НЬ БИДЭНД ИХ ЭЗЭНИЙ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ТУСАЛДАГ

Чуулга, ангийн ерөнхийлөгчийн зөвлөлд дараагийн ерөнхийлөгчийн зөвлөлийн хурлын бэлтгэл болгон [жишиг хөтөлбөрийг](#) бөглөхөд тусал. Дараах асуултуудыг хамтдаа хэлэлцэх талаар бодож үзээрэй.

- Яагаад жишиг хөтөлбөр дээрх шиг асуултуудыг авч үзэх нь чухал вэ?
- Бид өөр ямар хурал, үйл ажиллагаануудад ийм замаар бэлтгэж болох вэ?
- Хурлуудыг төлөвлөж, хөтлөн явуулахад Ариун Сүнс бидэнд тусалж болохын тулд бид хэрхэн Ариун Сүнсийг урьж чадах вэ? [Моронай 6:9](#); [Сургаал ба Гэрээ 46:2](#)-ыг үзнэ үү.

Та түүнчлэн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүдийг [Ирээд, Намайг дага —Аароны санваарын чуулга болон Залуу эмэгтэйчүүдийн ангиудад зориулав](#) гарын авлага дахь хичээл бүрийн тоймыг даган дараагийн чуулга эсвэл ангийн ерөнхийлөгчийн зөвлөлийн хуралд зориулсан хөтөлбөр бэлтгэхэд урьж болно. Ерөнхийлөгчийн зөвлөлийн хурлаараа авч хэлэлцсэн, түүнчлэн чуулгын болон ангийн гишүүдтэй хэлэлцэх шаардлагатай байгаа зүйлсийн талаар бодоход тэднийг урь. Хэрэв цаг гарвал та тэднийг бэлтгэсэн хөтөлбөрөө ашиглан хурлыг хөтлөн явуулах дадлага хийхэд урьж болно.

Та нар ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд хурлын талаар ямар сэтгэгдэлтэй байсныг үе үе ярилцаж болох юм. Хэлэлцүүлэгтээ дараахтай төстэй асуултуудыг тавьж болно. Үүнд:

- Хурал бидний төлөвлөсний дагуу болсон уу?
- Хуралдаа Сүнсийг урихын тулд бид юу хийсэн бэ? ([Сургаал ба Гэрээ 6:32](#)-ыг үзнэ үү.)
- Бид хүн бүрийг хамруулахыг хичээсэн үү?
- Бид хэрхэн сайжирч болох вэ?

НЭМЭЛТ ЭХ СУРВАЛЖ

- *General Handbook: Serving in The Church of Jesus Christ of Latter-day Saints*, [10.4](#), [11.3.4](#), ChurchofJesusChrist.org